



ДОРНОД АЙМАГ  
МАТАД СУМЫН ЗАСАГ ДАРГА

Зүүн булаг, Матад сум, 21020  
Утас: 88013991

2023.10.18 № 1/344

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ

Манай сумын нутагт Бүтээгдэхүүн Хуваах Гэрээт(БХГ)-ний хүрээнд Матад ХХ талбайд үйл ажиллагаа явуулдаг Петро Матад ХХК нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газраар батлуулсан ч энэ оны 11-р сарын 1-нийг хүртэлх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлант хугацаанд талбай дээр газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй.

Тиймээс Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.7-д заасны дагуу үйл ажиллагаа явуулаагүй болохыг энэхүү албан бичгээр тодорхойлж байна.

Хувийг: Петро Матад ХХК-д.

ДАРГА  Д.БАТТУЛГА



2102001236